



ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1120

Бэрх хот

Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр “Нийтлэг журам батлах тухай” (ААНБ-ын дотоод хяналт шалгалт)-ын тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Мичидмаа (Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Болорцэцэг (Татварын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Ш.Ганцэцэг (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө, журам, боловсруулж баталгаажуулж үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн орлогч (Н.Бахыт)-д даалгасугай

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Захирагчийн ажлын албаны даргын 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 040